



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/507

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн Засаг даргын 2017 оны А/525 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил хөтөлбөр”-ийн 4.2.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга Л.Пүрэвлхамын соёл судлалын ухааны докторын эрдмийн зэрэг хамгаалах зардалд 1300000 (нэг сая гурван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100890